

Цаг хугацааны талаарх эртний Грекийн философчидийн үзлүүд

Магистр Ц.Эрдэнэбат

Түлхүүр үг: Цаг хугацаа, орон зай, хөдөлгөөн, ертөнц.

Философийн сэтгэлгээний түүхэнд эртний Грекийн философичдын цаг хугацааны талаарх үзэл хандлага тодорхой байр суурь эзэлдэг. Тэд цаг хугацааг олон талаас нь тайлбарласан хандлага ажиглагддаг. Ямар ч баримт арга, баримт судалгаа байхгүй байсан эртний Грекүүд төгсгөлгүй тоог оролцуулан логик парадоксод оруулж, логик маргаануудыг шийдэн, шинэ ойлголтыг өөрсдийн оюун ухаандаа тунгааж байв. Энэ нь орон зай болон цаг хугацаа, бие хуваагдалт шинжийн талаарх асуудлуудыг тэр хэмжээгээр хэлэлцэж байжээ⁴² хэмээн Оросын эрдэмтэн Т. Я. Дубнищева дүгнэсэн байдаг.

Эртний Грекийн сэтгэгчидийн цаг хугацааны үзэл тэр дундаа Милетийн сургуультай үзэл нь материалист шинжтэй бөгөөд Ф.Энгельс байгалийн олон янзын эцэс төгсгөлгүй үзэгдлүүдэд, тэдгээрийг ямар нэгэн тодорхой биетээр, ямар нэгэн онцлог зүйлээр төлөөлүүлэн сэтгэж хөгжлийнхөө анхны үеүүдэд гэнэн анхдагч эхлэлийг авч үзсэн нь материализм дурайн харагдаж байна⁴³ гэж үзсэн байдаг. Иймэрхүү маягаар эртний Грекийн философи нь гэнэн материализмын шинжтэй үүссэн бөгөөд он тооллын хувьд МЭӨ VII-IV зуунд хамаардаг байна.

Эртний Грекийн сэтгэгчидийн нэг болох Милетийн сургуультай төлөөлөгч **Фалес** МЭӨ (625-547) нь цаг хугацааны талаар анх удаа авч үзсэн бөгөөд тэрээр ертөнцийн бүтцийн талаарх асуудлыг гүнзгий сонирхон, МЭӨ 585 онд Грект нарны хиртэлт болохыг ажиглаж мэдсэнээрээ алдаршиж байжээ⁴⁴. Фалес өөрийн газарзүй, одон орон судлал, физикийн мэдлэгээ ертөнцийн тухай философийн төсөөлөлтэй холбож үзсэн. Фалес оршин буй юмс чийглэг зүйл болох уснаас үүссэн. Бүх зүйлс байнга нэг л эх сурвалжаас төрж байдаг, газар дэлхий өөрөө эргэн тойрон усаар хүрээлэгдэж, усан дээр тогтож байдаг,...Оршин буй бүхний уг үндэс болсон ус нь үл устах, амьд шинжээр үл дутагдах эхлэл,...Ертөнцийн бүх л бурхад зүйлс амьтай... Ертөнц ямар эмх цэгцтэй нь тэнгэрийн гэрэлтэгч нар, сар, оддын харьцаагаар тодорхойлогддог⁴⁵ хэмээн Фалес астрономын тооцооны хэмжилтүүд дээр анхаарч байсан. Мөн тэрээр цаг хугацааны хөдөлгүүрийг оюун санаатай холбон авч үзээд цаг хугацаа нь оюун санаа хязгааргүй чөлөөтэй байх үед бодитой оршин байдаг. Гэвч ирээдүй ба өнгөрсөний ялгааг зөвхөн оюун санаагаар танин мэдэж болно гэж бичсэн байдаг. Мөн Фалес нарны жилийн хөдөлгөөнийг тодорхойлж жилийг 365 хоногт хуваан, анхны хуанлийг зохиосон байна⁴⁶. Фалес биенээс сэтгэлийг ялгаж үзсэн ч түүнийг материаллаг хэмээн үзсэн. Сэтгэл байгалийн бүхий л үзэгдэлийн эхлэл хэмээн⁴⁷ мөн сургаж байжээ.

Материализмын цаашдын хөгжилд дараагийн алхамыг хийсэн сэтгэгч бол Фалесын шавь **Анаксимандр** (МЭӨ 610-546) юм. Тэрээр олон талын мэдлэгтэй сэтгэгч байсны зэрэгцээ анхны нарны цаг болон газарзүйн картыг бүтээжээ.

⁴² Дубнищева. Т. Я "Концепций современного естествознания". М. 2000.с. 54

⁴³ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 8

⁴⁴ Там же. с. 24

⁴⁵ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976. с.25

⁴⁶ Дарьхүү. Р, Эрдэнэбаяр. Г "Философийн түүх".УБ, 2004. 106 дах тал

⁴⁷ "История философия". М, 1957. с.76-77

Тэрээр байгалийн мөнхийн болон, цор ганц үндсийг (тодорхойгүй, хил хязгааргүй) матери болох апейрон,...аливаа юмсын үүсэл болон устал нь Анаксимандрынхаар зайлшгүй байдлаас л урсан гардаг⁴⁸ гэж үзсэн.Эртний Грекийн материалистууд байгалийн үзэгдлийн тогтворгүй байдал болон мөнхийн хувирамтгай чанарын талаар сургадаг. Тэрээр бүхий л юмс нь хуурай болон чийглэг, халуун болон хүйтэн, эсрэг тэсрэг шинжид агуулагдаж байдаг нь апейроноос үүсэлтэй⁴⁹ болохыг сургасан. Мөн юмс үүссэнийхээ дараагаар цаг хугацааны нилээд хэсэг нь бүрмөсөн дуусан мөхөж устан, тэгснээрээ цаг хугацааны төгсгөлгүй тойрог хөдөлгөөн үүсдэг⁵⁰ болохыг дурдсан. Ертөнц гэдэг бол хэзээ ч төгсгөлгүй тасралтгүй үргэлжилдэг гэх түүний санаа нь олон тооны энергийн цаг хугацааны гадна орших бүх энергийн цаг хугацааны тухай асуудлыг гаргаж ирсэн байдаг.

Милетийн сургуультай сүүлийн төлөөлөгч болох **Анаксимен** ертөнцийн эхлэлийг агаар, уг агаар нь анхны биет, бүхний эхлэл болдог⁵¹, түүнчлэн агаарын сийрэгжилт болон нягтших тусламжтайгаар ус, газар, чулуу, гол зэрэг нь бий болдог⁵² гэж үзжээ. Мөн цаг хугацаа нь ертөнцийн оршихуй болон мөхлийг, үүслийг тодорхойлдог... Ертөнцийн үүсэл устал нь цаг хугацааны эмх цэгцийн дагуу үүсдэг⁵³ гэж сургасан байдаг.

Грекийн өөр нэгэн сэтгэгч **Гераклит** "Байгалийн тухай" хэмээн нэрлэгдэх бүтээлээ тухайн үед туурвижээ. Гераклит эртний Грекчүүдийн үзлийн нэг болох хөдөлгөөний талаар, тэр хөдөлгөөн нь байгалийн уг чанар болдог талаарх адилхан үзлийг гаргасаныг онцлон тэмдэглэдэг. Гэвч Грекийн тахилгачаас эхлээд Гераклитыг хүртэл бүгд л бурхны талаар, математик болон одон орны талаарх үзлийг номлож байсан онцлогтой. Платон өөрийнхөө "Кратил " хэмээх диалогтоо Гераклит бүх юмс ямар ч тайван байдалд байдаггүй, хөдөлж байдаг ба нэг голын усанд хоёр удаа орж болохгүй⁵⁴ гэсэн нь голын ус байнга шинэ усаар шинэчлэгдэн сэлбэгдэж байдаг өөрөөр хэлбэл бүгдээрээ өөрчлөгдөж, ертөнц урсгал шинжтэй гэсэн санааг агуулж байна.

Хөдөлгөөн гэдэг бол ертөнцийн амьдралын үйл явцуудын нилээд нийтлэг шинж бөгөөд тэр нь бүх л үзэгдэл болон судлагдахуун дээр, бүхний уг чанарт нь тархагдсан байдаг. Хөдөлгөөний нийтлэг шинжийн тухай сэдэв мөнхийн хөдөлгөөнөөр хөдлөгдөж байдаг мөнхийн зүйлс мөн цаг хугацааны хөдөлгөөнөөр хөдлөгдөж байдаг үүсгэгч юмсад, цор ганц зүйлсэд хандаж байдаг. Мөнхийн хөдөлгөөн гэдэг бол мөнхийн хувиралттай цуг байдаг. Аристотелийн гэрчилснээр Гераклит өдөр бүр шинэ нар гарч, нар нь байнга тасралтгүй шинэчлэгдэж байдаг⁵⁵ гэж өгүүлсэн байдаг.

Даяар юмс, бүхий л хөдөлгөөн, үзэгдэл нь цорын ганц үндэстэй байдаг. Энэ ганц зүйл нь маш хатуу чанга зүй тогтолт шинжээр дүрслэгдэн: сэтгэгч судалгаагаараа түүнд гарцаагүй байх, зонхилогч шинжийг илрүүлдэг. Гераклит энэ сэтгэлгээгээ зарим афоризмдаа өгүүлсэн ба түүний гуч дах афоризмд нь энэ ертөнцийн эмх цэгц гэдэг бол гэдэг бол бүхий л юмстай адил, хэн ч, бурхан ч, хүн ч баталдаггүй, тэр нь үргэлж хэмжээгээрээ асаж байдаг, хэмжээгээрээ унтарч, мөхөж байдаг мөнхийн амьд гал юм⁵⁶ гэж дүрсэлсэн байдаг. Гераклитын энэ санаа нь түүний ертөнцийн цаг хугацааны хэмнэлт шинжийг дүрсэлсэн хэлбэр юм.Мөнхийн хөдөлгөөн болон анхдагч эхлэл галаас бүхий л юмс эхлэлтэй гэх Гераклитын үзэл нь цаг хугацааны агуулгатай, аливаа юмс

⁴⁸ Там же. с.77

⁴⁹ Там же

⁵⁰ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 26

⁵¹ Аристотель "Сочинение". М, 1976. с.72

⁵² Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 26

⁵³ Таранов. П "Мудрость трех тысячелетий". М, 1999.с.35

⁵⁴ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976. с.33

⁵⁵ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 33

⁵⁶ Там же. с.34

мөнхийн, үл устах, цаг хугацааны хувьд төгсгөлгүй, тасралтгүй үргэлжлэлт шинжтэй гэж дүгнэхэд хүргэж байна.

МЭӨ VI зууны сүүл V зууны II хагаст хамаарах Элейн сургууль нь тэр үеийн Гераклит болон Анаксимен гэх мэт Ионийн материалистуудын эсрэг, тэднийг шүүмжлэн гарч ирсэн сургууль юм. Тэр сургуультаны гол төлөөлөгчид нь **Парменид** ойролцоогоор (540) онд төрсөн, **Зенон** (480-430) нар юм.

Парменид сэтгэлгээ бол үргэлж юмсын тухай сэтгэлгээ байдаг, сэтгэлгээг эд юмсаас тусад нь, ахуйгаас салангид авч үзэх боломжгүй, сэтгэлгээ бол үргэлж ахуй⁵⁷ хэмээн үзсэн төдийгүй бид эцэстээ ахуй нь ахуй бус л байдаг хэмээн сургасан. Парменидынхаар ахуй гэдэг бол хоосон, хоосон орон зай юм.

Парменид "Уг чанарын тухай" гэх өөрийн бүтээлдээ мэдрэхүйгээр өгөгдөж байдаг бүхий л зүйл хоосон, худал хуурмаг⁵⁸ болохыг тэмдэглээд цорын ганц үнэн ахуй бол төгсгөлгүй, үл хуваагдах бүхэллэг ахуй юм хэмээн үзсэн. Парменид өөрийн сургаалаа "үнэний зам", "санааны зам" хэмээн нэрлээд хоёдох хэсгээ байгалийн физикийн бодит үйл явцыг бус харин пифагорчуудын физик таамаглал⁵⁹ гэж үзсэн бөгөөд Парменид Пифагорчуудын физикт ихээхэн ач холбогдол өгөн, тэр бодит хоосон ахуйг үгүйсгэхэд үгүйсгэх үндэс нь болсон байна.

Парменид бид өнгөрсөнийг танин мэдэж болох ч үнэндээ өнгөрсөнийг танин мэдэх боломжгүй, гэвч тодорхой сэтгэхүйн хүрээнд одоо цаг л оршин байдаг. Эндээс бид ямар ч юмс өөрчлөлт хувьсал гэж байдаггүй⁶⁰ гэсэн дүгнэлтийг хийсэн нь өнгөрсөн зүйл гэж байх боломжгүй, юмс өөрчлөгддөггүй зөвхөн одоо байгаагаараа л оршин байдаг гэх санааг дэвшүүлсэн байна. Парменид мэдлэгийг оюун ухаан болон мэдрэхүйн гэж хоёр төрөлд авч үзэн, мэдрэхүйн мэдлэг үнэн мэдлэгийг өгч чаддаггүй, харин оюун ухааны мэдлэг үнэнийг өгөх боломжтойг дурдсанаас үзвэл цаг хугацааны талаар Парменидын үзэл нь оюун ухааны мэдлэгт хамааралтай, ямарваа бодит хөдөлгөөн, олонлог, хувирал байдгийг үгүйсгэн түүнийгээ нотлохыг оролдсон нь цаг хугацааг оюун ухаантай, сэтгэхүйн хүрээнд авч үзэж байсан нь илт байна.

Элейн сургуултаны бас нэгэн төлөөлөгч нь Зенон бөгөөд Парменидын аргументыг нарийвчлан хөгжүүлсэн сэтгэгч юм. Тэрээр өөрийнхөө үзлийг гаргахын тулд нөхцөлт байдлаар Парменидыг эсрэг сэдэл гарган 1. Орон зай гэдэг бол хоосныг сэтгэх, 2. Олонлогийг, ахуйн оршихуйг сэтгэх, 3. Хөдөлгөөнийг сэтгэх боломжтой⁶¹ гэжээ. Эдгээр гурван нөхцлийг Зенон зайлшгүй байдлаас сөргүүлэн авч үзсэнээрээ энэ нь худал гэдэг нь батлагддаг. Хэрвээ тэд хуурмаг байвал үнэнд сөргөлдөн батлагдах ёстой гэж Зенон сургажээ.

В. И. Ленин "Философийн дэвтрүүд" зохиолдоо: Парменид, Зенон нь бидний мэдрэхүйн хүрээнд хөдөлгөөн олонлог, хоосны бодит үгүйсгээгүй. Тэд хөдөлгөөнийг, олонлогийг, хоосныг сэтгэх боломжтойг л үгүйсгэн, ингэснээрээ зөрчилд ордоггүй⁶² гэжээ.

Зенон хөдөлгөөн олонлогийн орон зайн талаар батлахдаа "Дихотомия", "Ахилл", "Нисэж буй сум" гэх мэт аргуудтааар тайлбарласан. Бүх л оршин буй юмс хаа нэгэн орон зайд оршдог. Гэвч орон зайд оршихын тулд бас л хаа нэгэн хоёрдох орон зайд оршдог. Энэ хоёрдох орон зай нь мөн л гуравдах орон зайд оршдог гэх мэтээр тасралтгүй байдлаар сэтгэгддэг⁶³ гэж үзсэн ч эцэстээ орон зай гэдэг бол үл сэтгэгдэх юмсаас тусгаар байдаг гэж дүгнэх болдог.

Эндээс цаг хугацаа нь орон зайтай адил үл төгсөх, тасралтгүй байдаг гэж дүгнэж болно. Үүнийгээ Зенон Дихотомия апоридоо батладаг. Мөн Зенон

⁵⁷ Там же. с.45

⁵⁸ Рассел. Б "История западной философий". Новосибирск, 1999.с. 61

⁵⁹ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976. с.48

⁶⁰ Рассел. Б "История западной философий". Новосибирск, 1999. с.64

⁶¹ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 52

⁶² Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 52-53

⁶³ Там же.с. 53

хамгийн хүсэшгүй шижлэх ухааныг эзэмшинэ гэдэг бол биеэ тоосон хэрэг, харин хамгийн хэрэгтэй зүйлийг эзэмшинэ гэдэг бол цаг хугацаа⁶⁴ гэж үзсэн байдаг.

Эмпедокл нь МЭӨ 440-д оны үед амьдарч байсан бөгөөд энэ сэтгэгч гайхамшгийг бүтээгч, эмч гүн ухаантан байсан талаар олон домогт өгүүлсэн байдаг. Эмпедокл ойролцоогоор гурван мянгаад шүлэг, найраглал зохиосон ч өдгөө зуугаад нь уламжлагдан ирсэн. Түүний үзлээр аливаа ертөнцийг тайлбарлахын тулд түүний уг үндсийг гаргах хэрэгтэй. Тэр уг үндэс болох гал, агаар, ус, шороо гэх дөрвөн элементийн холдолт, ойртолтоор юмс үүсэн эсвэл мөхөж байдаг ба эдгээр элементүүд хос хосоороо эсрэг хөдлөгч хүч болдог⁶⁵ аж.

Платон: Эмпедокл болон Гераклитын диалектикийн ялгааг онцлон, Гераклит бүх эсрэг тэсрэг зүйлс нэгэн зэрэг оршин байдаг талаар номлож байсан бол Эмпедокл үүний эсрэг илүү "эмзэг" үзлийг дэвшүүлж байна. Энэ нь түүний үзлээр онол болон бүхэл эсрэг тэсрэг шинжүүд, хайр болон дайсагнал зарга нэгэн зэрэг бус харин дагалдаж байдаг⁶⁶ гэж сургасан. "Дайсагнал", "ноёрхол" байх үед ертөнцөд элементүүд салж, мөхөж байдаг харин "хайр" ноёрхож байхад ялалт, ямар нэгэн зүйлс үүсэж энэ хоёр ээлжлэн ертөнцийн төвийг булаацалдаж байдаг. Ертөнцийн үйл явц давтамжит шинжтэй, мөнхийн энэ эргэлтэнд оршин байдгийг онцолсон.

Эмпедоклын энэ үзэл нь цаг хугацаа бол давтамжит шинжтэй, цаг хугацаа нь хэмнэлт байдлаар мөнхийн хөдөлж байдаг гэсэн санааг дэвшүүлсэн нь илэрхий. Мөн Эмпедокл ертөнц хоёр хагас бөмбөрцгөөс тогтдог ба нэг нь гал нөгөө нь агаартай холилдон тогтдог. Энэ хоёрын эргэлтийн үр дүнд өдөр шөнө солигддог. Сар нь өөрөө гэрэлтдэггүй, энэ нь нарнаас тусах гэрэл болохыг, нарны гэрэл дэлхийд хэдий хэр хугацаанд тусаж болохыг тооцож байсан нь цаг хугацааны, орчин үеийн онолын угтвар нөхцөлийн эх үндсийг тавьсныг гэрчилнэ. Үүнийг анх XVII зуунд Олаф Рёмер гэх эрдэмтэн нарны цацрагийн хурд 300000 км/с хурдтайг тогтоосоныг Эмпедокл МЭӨ IV зуунд туршиж байсан байна.

МЭӨ (500-428) оны хооронд амьдарч байсан Эртний Грекийн философид зохих хувь нэмрээ оруулсан сэтгэгч бол **Анаксагор** юм. Тэрээр материализмын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн сэтгэгч ба ертөнц гэдэг бол эмх цэгцгүй материаллаг биетүүдээс тогтдог оюун ухааны үйл ажиллагааны оршин буй ертөнцийн бүтэц бий болсон⁶⁷ хэмээгээд оюун ухааны дор бие бус цэвэр эхлэлийг ойлгож байсан.

Анаксагор математикийг илүү анхаарахын зэрэгцээ астрономи болон цаг уур шинжлэлд судалгаа явуулдаг байжээ. Анаксагор Эмпедоклын адил ертөнцийн эхлэлийг эгэл бөөмсүүдээр төлөөлүүлж байсан ч яг Эмпедоклын адил гал, ус, хий, шороо гэж дөрвөн элементээр хязгаарласангүй харин хязгааргүй олон хамгийн жижиг хэсгүүдийн задрал нэгдэлээр, үүсэл мөхлийг, анхдагч эхлэлийг тайлбарлаж байжээ. Аристотель "Метафизик" зохиолдоо хязгааргүй олон эхлэл нь түүний өгүүлснээр ус эсвэл гал нь гомеомери болохынхоо хувьд үл үүсэх, үл устах бус, гагцхүү нэгдэл, задралын замаар үүсэж мөн устгагдаж байдаг⁶⁸ гэж тэмдэглэсэн. Мөн Анаксагор төгсгөлгүй материйн тоон элементүүд бүгд олон янзын зүйлийг бүтээж байдаг ба өчүүхэн жижиг үл хуваагдах зүйлүүд оршин байдаггүй харин төгсгөлгүй хуваагдах үйл явц гэж байдаг⁶⁹ гэж үзсэн.

Эртний Грекийн сэтгэгчид, цаашлаад Анаксагор анхдагч эхлэл, ертөнцийн үүслийн талаар тайлбарлахдаа ямар нэгэн биет бус зүйлсэд оноон, түүнийгээ

⁶⁴ Таранов. П "Мудрость трех тысячелетий". М, 1999. с.151

⁶⁵ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.с. 61

⁶⁶ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976. с.20

⁶⁷ Там же, с.76

⁶⁸ Аристотель "Сочинение". М, 1976. с.72

⁶⁹ Дубнищева. Т. Я "Концепций современного естествознания". М. 2000.с. 54

мөнх, хязгааргүй. эцэс төгсгөлгүй хэмээн тодорхойлж батлахын тулд олон онол, аргуудыг дэвшүүлж байсан нь угтаа цаг хугацааны утгыг давхар агуулсан, мөнхийн гэсэн санааг илрүүлсэн хэрэг юм. Анаксагор ертөнцийн хөдөлгөгч хүчийг "оюун ухаан"⁷⁰ гэж тодорхойлоод уг хөдөлгөгч хүч "оюун ухаан" нь ертөнцийг бий болох үйлд оролцогч бөгөөд "оюун ухааныг" тодорхойлоход төвөгтэй ч оюун ухаан нь ертөнцийн тойрог хөдөлгөөнд ерөнхий дамжуулагч, өнгөрсөнд ч байсан, одоо ч байгаа, бүхий л эмх цэгц нь оюун ухаанаар тодорхойлогддог⁷¹...ухамсрын, оюун ухааны хүч гэж үздэг байна.

Анаксагорын онтологи үзэл нь цаашлаад Левкип болон Демокритын үзлийг хэлбэржихэд чухал нөлөө үзүүлсэн.

Демокрит атомын тухай сургаалаа боловсруулахад нь өмнөх сэтгэгчидийн үзэл нөлөөлсөн бөгөөд "атом" гэх үг нь Грекийн "Атомос" цаашид үл хуваагдах хамгийн жижиг гэсэн утгатай. Атомууд нь тооны хувьд хязгааргүй олон бөгөөд цааш үл хуваагдах, үл устгагдах туйлын нягт, өөрөө хөндий, хоосон орон зайд агуулагддаггүй, бөгөөд атомууд дотооддоо бус харин биет зүйл дээр хэлбэрээрээ, хэмжээгээрээ, байдал эмх цэгцээрээ бие биенээсээ тусгаар байдаг⁷². Атомууд нь зөвхөн эцэс төгсгөлгүй байдаг гэж үзсэн ч атомууд нь олон янзын төлөв хэлбэрүүдтэй байх боломжтой. Атомууд нь бөмбөлөг, пирамид, олон дүрст гэх мэт өөрийн олон янзын хэлбэрээрээ оршин байдаг. Эдгээр хэлбэр нь хязгааргүй их байдгийг өгүүлэн хөдөлгөөнийг өмнөх сэтгэгчидийн адил тусгаар хөдөлгөгч биетээр тодорхойлсонгүй харин хөдөлгөөн нь атомын үндсэн шинж гэж үзсэн. Демокритын энэхүү өвөрмөц үзэл нь цаг хугацааны мөнхийн шинжтэй салшгүй холбоотой.

Демокритын үзлээр, орон зай бол эцэс төгсгөлгүй, нэгэн төрөлт, объектив байдаг. Орон зай нь атомуудыг агуулагч сав юм. Цаг хугацааг мөнх шинжтэй адилтган, энэ нь цэвэр үргэлж шинжтэй, өнгөрснөөс ирээдүй тэгш хэмээр урсдаг. Цаг хугацаа бол нөхцөл байдлыг агуулагч сав⁷³ гэж оросын эрдэмтэн Т. Г. Лешкевич өөрийн бүтээлдээ дурджээ. Цаг хугацааны мөнх шинж нь Демокритын хувьд үл үүсэгч ахуйг батлах аргаар гаргаж ирсэн гэж Аристотель тэмдэглэсэн байдаг⁷⁴. Платоноос гадна бүх философичид Аристотелийн өгүүлсэн цаг хугацааг үл үүсдэг гэж үзсэн. Иймээс Демокрит бүх зүйлийн үүслийг мэдэх боломжгүйг батлан, иймээс цаг хугацааны анхдагч үүсэлийг мэдэх боломжгүй⁷⁵ хэмээн Аристотель "Метафизик" зохиолдоо тэмдэглэсэн. Цаг хугацааны талаарх Демокритын үзэл нь түүний атомын тухай сургаалтай холбоотой бөгөөд орчлон ертөнцийн мөнх шинжтэй гэх ойлголттой адилтган авч үзээгүй. Орчлон ертөнц гэдгээрээ бүхий л атомын цогц мөнхийн шинжийг авч үзсэн ба үүний эсрэг нь бодит ертөнц нь мөнх бус бөгөөд тэр нь үүсдэг, тодорхой цаг хугацаанд оршин байдаг ч атомд л хуваагдаж, сарнин устдаг⁷⁶ гэсэн.

Демокрит цаг хугацааны мөнх шинж болон материаллаг эхлэлээс байгалийн бүхий л үзэгдэл үйл явцын зайлшгүй байдал үүсдэг хэмээн цаг хугацааны үзэл, өмнөх сэтгэгчидтэй харьцуулахад биеэ даасан категори байдлаар авч үзсэн нь цаашдын цаг хугацааны бие даасан категори ойлголт, нэр томъёоны философи агуулгад нөлөө үзүүлсэн.

Эртний Грекийн Платон диалектик, танин мэдэхүйн онол, эстетик, сурган хүмүүжүүлэх ухааны асуудлуудыг боловсруулсан. Платоны боловсруулсан гол ойлголт нь "Эйдос" юм. Тэрээр өмнөх Элейн сургуультай зарим санааг хүлээн

⁷⁰ Асмус. В. Ф. "Античная философия". М, 1976. с.87

⁷¹ Там же. с. 88

⁷² Там же. с. 138

⁷³ Лешкевич. Т. Г. "Философия-Вводный курс". М, 1998. с. 281

⁷⁴ Асмус. В. Ф. "Античная философия". М, 1976. с. 145

⁷⁵ Там же. с. 27

⁷⁶ Там же. С. 149

зөвшөөрсөн бөгөөд ямарваа зүйл дэх жинхэнэ мөн чанарыг ойлгож мэдэх ёстой ба бидний мэдрэн хүртэж буй зүйлс угтаа жинхэнэ мөн чанар бус.

Платоны "сайхны" талаар авч үзсэн нь сайхан морь, сайхан бүсгүй, гэх мэт байдаг. Угтаа эдгээр нь сайхны илрэл болохоос бус жинхэнэ сайхан нь биш⁷⁷. Аливаа зүйлс энэ сайхны тухай шиг илэрч байдаг бидэнд мэдрэгдэх тэр зүйлс харьцангуй шинжтэй устаж, эвдэрч, өөрчлөгдөж болох талтай ч түүний цаадах мөн чанар нь үл устах, мөнхийн шинжтэй "эйдос" юм гэж сургасан байдаг. Энэ "эйдос" нь мэдрэхүйн тодорхой зүйлээс орон зай болон цаг хугацааны хил хязгаар, нөхцөх байдлаас үл хамаарах, харьцангуй бус, объектив гэх мэт шинжтэй⁷⁸. Энэ нь бүхнээс дээгүүр сэтгэгдэгч мөнхийн "эйдос" гэж үзсэн нь ийм маягаар нилээн тодорхой бус, шууд бус сэтгэлгээ нь орон зай болон цаг хугацааг, тоог л тодорхойлоход хэрэглэх боломжтой. Платоны "санаа" буюу "эйдос" нь аливаа юмсын цаад, ямар нэгэн мэдрэхүйн туршлагын хэлбэрээр, ойлголт болон тоо, орон зай, цаг хугацааны ойлголтууд нь үгээр илэрхийлэгдэшгүй байдлаар тайлбарлагддаг. Мөн Платоны хувьд орон зай болон цаг хугацаа нь бие даасан мөн чанартай, материас ч, бие биенээсээ ч үл хамааран байдаг гэж тайлбарласан⁷⁹ түүний телеологи нь бүхэнд зохицолт шинжийн талаар сургаал юм. Учир нь Платоныхоор бүхний дээр буяны "санаа" тэргүүлдэг. Өөрөөр хэлбэл энэ нь ертөнцөд ноёлогч эмх цэгц гэсэн утгатай.

Аливаа цаг хугацааны харьцангуй ахуй бол бид ямар нэгэн объектив ахуйн зорилго нь байдаг. Мөн Платон дээрх дурдсаны адил сайхны тухай өгүүлэхдээ: сайхан гэдэг нь үргэлж мэдрэхүйн юмсад өөрчлөгдөж хувирч байдаг. Сайхан гэдэг нь орон зай болон цаг хугацаанаас, орон зайд орших мэдрэгдэгч зүйлсээс үл хамааран цаг хугацаанд үүсэж, устаж, өөрчлөгдөж байдаг⁸⁰. Платон дээрх ойлголтуудыг цаг хугацаанаас үл хамаардаг хэмээн гаргаж ирсэн нь цаг хугацааны талаарх ойлголтыг тусд нь илэрхийлж буй эхлэл юм.

Платон ертөнцийн талаарх сургаалдаа цаг хугацааг авч үзсэн нь илэрхий. Үүнд Пифагорчуудын гариг ертөнцийн тайлбарлалыг гүнзгийрүүлэн цаг хугацааныхаа тайлбарлалыг гаргасан. Эцэг "бурхан" шалтгаан үрийг харгалзан, үүнийгээ хөдөлдөг, мөн амьдардаг мөнхийн бүтээгч эзэн хэмээн тэрээр "бүтээл" мэтээр зүйрлэсэн. Иймээс тэр загвар нь өөрөө мөнхийн амьд мөн чанар болдог ба тэр хэмжээний хувьд боломжтой, төстэй болгохыг чармайсан. Гэвч тэр үйл нь мөнхийн амьд мөн чанарын уг чанарт нь байхад үүнийг ямар нэгэн төрөлхийн байдалд бүрэн шилжүүлж болохгүй: бидний цаг хугацаа гэж нэрлэсэн тооноос тоонд хөдлөгч, мөнхийн хэлбэр, нэгдмэл болгогч, мөнхийн шинжийг тэнгэртэй хамт бүтээн бий болгожээ. Энэ өдөр ч шөнө ч байсангүй. Бид тэр байсан эсвэл байх ч болно гэж мөнхийн мөн чанарын талаар ярих ёсгүй. Үнэндээ тэр нь байсан байх болно гэж хэлсэн "хөдөлгөөний мөнхийн шинжит хэлбэрийн" тухай л ярьцгаана. Цаг хугацаа болсон тэнгэр нь нэгэн агшинд л үзэгдсэн⁸¹ гэжээ. Платон цаг хугацааны талаарх тайлбарлалаа тэнгэр бурхантай адилтган теологийн үүднээс тэнгэртэй зүйрлэн өгүүлсэнээрээ цаг хугацааг объектив шинжтэйг илэрхийлж байна.

Аристотель МЭӨ (384-323) оны хооронд амьдарч байсан бөгөөд олон бүтээл туурвисны дотроос цаг хугацааны үзлээ "Метафизика" зохиолдоо голлон тусгажээ. Цаг хугацааны талаарх түүний үзэл нь хөдөлгөөний мөнхийн шинжээс үүдэлтэй тайлбарлагддаг. Хөдөлгөөн нь үүсэж ч, устах ч боломжгүй байдаг. Тэр үргэлж оршин байсан. Тиймээс цаг хугацаа гэдэг бол үүсэж эсвэл устгагдах боломжгүй; хэрвээ цаг хугацаа гэж байдаггүй бол "эрт", "орой" гэж байх

⁷⁷ Дарьхүү, Р. Эрдэнэбаяр. Г "Философийн түүх". УБ., 2004. 130 дах тал

⁷⁸ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976. с.186

⁷⁹ Лешкевич. Т. Г "Философия-Вводный курс". М, 1998. с.280

⁸⁰ Асмус. В. Ф "Античная философия". М, 1976. с.192

⁸¹ Рассел. Б "История западной философий". Новосибирск, 1999.с. 149

боломжгүй. Хөдөлгөөн нь цаг хугацаа шиг иймэрхүү байдлаар тасралтгүй байдаг гэсэн утгатай⁸². Мөн Аристотель "Сэтгэлийн тухай" бүтээлдээ цаг хугацааны сэтгэхүйн талаар, оюун төрөл болж үл хуваагддаг талаар авч үзэхдээ цаг хугацаатай холбон тодорхойлсон байна.

Аристотель ямар нэгэн өнгөрсөн болон ирээдүйн талаарх бодрол нь цаг хугацаатай холбогдож ойлгогддог. Алдаа гэдэг бол үргэлж зүй бус зүйлтэй холбогдож үүсдэг. Үнэндээ хэн муу зүйлийг муу гэж сэтгэнэ түүнийг муу биштэй хослуулж ойлгодог. Үүнийг хуваагдал хэмээн нэрлэж болно. Хүн үүнийг оюун ухаандаа л хослуулдаг болохыг өгүүлээд цааш нь үл хуваагдал гэдгийг хоёр янзаар ойлгох боломжтой. Энэ нь бололцоолог болон бодит байдал хэмээн, иймээс түүний үл хуваагдах болон цаг хугацаанд үл хуваагдах сэтгэлгээтэй, орон зайлаг сэтгэлгээтэй юуг ч хольж хутгаж болохгүй. Цаг хугацаа гэдэг бол орон зайлаг шинжтэй адил хуваагдах болон үл хуваагдах шинжтэй байдаг. Тэгэхээр цаг хугацааны үе бүхэнд оюун ухаан сэтгэдэг гэж ярьж болохгүй⁸³. Хэрвээ олон тэнгэр байсан бол мөн тийм маягаар цаг хугацаа нь тэднээс үүсэн дурын хөдөлгөөнд байх байсан. Иймээс нэг дор олон цаг хугацаа байх байсан⁸⁴ гэжээ.

Ертөнц дээр бодитой оршин буй бүхий л зүйлс хувирч, өөрчлөгдөж байдаг. Хувирч өөрчлөгддөггүй юм нэгээхэн ч үгүй. Угтаа тэр хувирал өөрчлөлтийг цаг хугацаа гэж нэрлэж байна. Тийм учир Н. И. Лабочевский хөдөлгөөнтэй холбоотой цаг хугацааг тодорхойлох оролдлого хийсэн байдаг. Тэрээр өөрийн механикийн талаарх лекцдээ "бусадтай харьцуулсанаар үүсэн гарах тэрхүү хөдөлгөөний нэг нь, мөн дангаараа төгсгөлгүй үргэлжлэх хөдөлгөөнийг нэгэн жигд гэж нэрлэгддэг нь үнэндээ цаг хугацааг хэлж буй хэрэг юм"⁸⁵ гэж үзсэн байдаг нь үүнтэй холбоотой биз. Эртний Грекийн сэтгэгчидийн цаг хугацааны талаарх үзэл нь хожмын цаг хугацааны үзэлд чухал нөлөө үзүүлсэн.

Ном зүй

1. Аристотель "Сочинение". М, 1976.
2. Асмус. В. Ф "Античная философия". М, 1976.
3. Аскин. Я. Ф "Проблема времени ее философское истолкивание" М. 1966.
4. Дарьхүү. Р, Эрдэнэбаяр. Г "Философийн түүх". УБ, 2004.
5. Дубнищева. Т. Я "Концепций современного естествознания". М. 2000.
6. "История философия". М, 1957.
7. Лешкевич. Т. Г "Философия-Вводный курс". М, 1998.
8. Рассел. Б "История западной философий". Новосибирск, 1999.
9. Таранов. П "Мудрость трех тысячелетий". М, 1999.

⁸² Аристотель "Сочинение". М, 1976. с.307

⁸³ Аристотель "Сочинение". М, 1976. с.436

⁸⁴ Вестн. Моск. Ун-та. Сер. 7. Философия. 2001. №2.с. 79

⁸⁵ Аскин. Я. Ф "Проблема времени ее философское истолкивание" М. 1966.с. 74